

## **ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ, АНГИЛАХ, ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, СЭРГЭЭН АШИГЛАХ, УСТГАХ, БУЛШЛАХ ЖУРАМ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү журмаар Дархан-Уул аймгийн айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагаас үүсэх хог хаягдлыг эх үүсвэр дээр багасгах, ангилан ялгах, ангиллын дагуу хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх, нийтийн эдэлбэр газрыг цэвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах үйл ажиллагааг эрхлэхэд үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Журам нь Хог хаягдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомж болон бусад актаас бүрдэнэ.

1.3. Журмыг Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт ажиллаж, амьдарч байгаа оршин суугч иргэд болон үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгж, байгууллагууд дагаж мөрдөнө.

1.4. Энэ журмаар аюултай хог хаягдалтай холбоотой үйл ажиллагааг зохицуулахгүй.

1.5. Журмын хэрэгжилтэд бүх шатны Засаг дарга, Мэргэжлийн хяналтын улсын байцаагч, цагдаа, хог хаягдлын олон нийтийн байцаагч хууль тогтоомжоор эрх олгогдсон албан тушаалтан, гэрээгээр эрх олгосон төрийн бус байгууллага, олон нийтийн хяналтыг иргэдийн бүлэг, иргэн тавина.

1.6. Энэхүү журамд заасан хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, ангилан ялгах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг хангасан /Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар баталсан ерөнхий шаардлага/ аж ахуйн нэгж, байгууллага Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлснээр гэрээ байгуулах эрхтэй болно.

### **ХОЁР. АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА, СУМ, БАГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЧИГ ҮҮРЭГ**

2.1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын чиг үүрэг:

2.1.1. Журмын хэрэгжилтэд хяналт тавих

2.2. Дархан-Уул аймгийн Засаг дарга бөгөөд хотын Захирагчийн чиг үүрэг:

2.2.1. Журмын хэрэгжилтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын өмнө хариуцаж, тайлагнах

2.2.2. Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх байгууллагад зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах

2.2.3. Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, булшлахад шаардагдах төсөв, техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах

2.2.4. Энгийн хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булж устгах байгууллагын үйл ажиллагааны хүчин чадал, менежментийг үнэлэх аргачлалыг батлах

2.2.5. Хуваарьт болон хуваарьт бус бүх нийтийн цэвэрлэгээг зарлах

### 2.3. Захирагчийн ажлын албаны чиг үүрэг:

2.3.1. Аймгийн нутаг дэвсгэр дэх энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, ангилан ялгах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангах, хяналт тавих

2.3.2. Сумдын хилийн цэс харгалзахгүйгээр цэвэрлэгээ хийх нийтийн эзэмшлийн газарт хамаарах гудамж, зам талбай, алслагдсан зам, замын байгууламжийн жагсаалтыг батлах

2.3.3. Аймгийн хэмжээнд хог хаягдлын талаарх сургалт, сурталчилгааны нэгдсэн арга зүйг боловсруулах

2.3.4. Журмын 2.2.4-т заасан үнэлгээнд улирал бүр хяналт тавьж, үнэлгээний бодит байдалд дүгнэлт гаргах

### 2.4. Сумдын Засаг даргын чиг үүрэг:

2.4.1. Сумын хилийн цэс доторх нийтийн эзэмшлийн газарт хамаарах гудамж, зам талбайн жагсаалт батлах

2.4.2. Журмын 2.2.4-т заасан аргачлалын дагуу энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх байгууллагын үйл ажиллагааны хүчин чадал, менежментийн үнэлгээг улирал тутам хийж, үр дүнг аймгийн Захирагчийн ажлын албанд тайлагнах

2.4.3. Бүх нийтийн цэвэрлэгээнд хамрагдах сумын нутаг дэвсгэрийн гудамж, зам, талбай, ногоон бүсийн зураглалыг гаргаж, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгж, байгууллага, их, дээд сургууль, коллеж, ерөнхий боловсролын сургуульд зураглалаар хариуцуулан, хуваарь гарган батлах

2.4.4. Хог хаягдлын талаарх сургалт, сурталчилгааг тусгайлан боловсруулсан арга зүйн дагуу улирал тутам хийж, нутаг дэвсгэр дэх иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудыг хамруулах

2.4.5. Сумын нийтийн эзэмшлийн газар, гудамж, талбайд гурваас доошгүй төрлөөр ангилан ялгах хогийн савыг журмын 6.4-д заасан байршлуудад байршуулах, шаардагдах төсвийг тухайн жилийн төсөвт тусгуулах

2.4.6. Сумын хэмжээнд журмын хэрэгжилтийг хангуулах, ил задгай хог хаягдал үүсэхгүй байх арга хэмжээг авч ажиллах

2.4.7. Сумын нутаг дэвсгэрт хог хаягдал цуглуулж, тээвэрлэх үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэн, аж ахуй нэгжийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр нээлттэй сонгон шалгаруулж, гэрээ байгуулан гүйцэтгүүлэх

2.4.8. Аж ахуй нэгж, байгууллага, иргэний төлөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийг Хог хаяглын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2-т заасан хэмжээгээр тооцож авахад хяналт тавих, үйлчилгээний хураамжийн орлого төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх

2.4.9. Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.7, 9.4.14-д заасан олон нийтийн байцаагч ажиллуулах, шаардагдах төсвийг тухайн жилийн төсөвт тусгах

2.4.10. Сумын газар нутгийн онцлогоос хамаарч ангилсан хог хаягдлыг худалдан авах, түр хадгалах цэгийн байршлыг тогтоох

2.4.11. Зам талбайн цэвэрлэгээг батлагдсан тариф /хавсралт №2/-г үндэслэн цэвэрлэгээний зардлыг тусгах

### 2.5. Багийн Засаг даргын чиг үүрэг

2.5.1. Багийн иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудыг хог хаягдлын чиглэлээр зохион байгуулж буй сургалтуудад хамруулах

2.5.2. Хог ачиж тээвэрлэх, цуглуулах хуваарийн хэрэгжилтэд хяналт тавих

2.5.3. Хог хаягдлын олон нийтийн байцаагчийн үйл жиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах

2.5.4. Оршин суугчид, аж ахуй нэгж, байгууллагуудын бүх нийтийн цэвэрлэгээнд оролцсон талаар бүртгэл хөтлөх, оролцоог хангах

### **ГУРАВ. АЖ АХУЙ НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБОО, ИРГЭДИЙН ЧИГ ҮҮРЭГ**

3.1. Аж ахуй нэгж, байгууллага орчны 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн газар, зам талбайн хог, хаягдал, шарилж, лууль зэрэг ургамал, цас мөсийг өдөр бүр цэвэрлэх

3.2. Журмын 3.1-т заасан үүргийг гүйцэтгэхгүй тохиолдолд сумын Засаг дарга мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд гарсан зардлыг тухайн аж ахуйн нэгж, байгууллага хариуцах

3.3. Аж ахуйн нэгж, байгууллага нь бүх нийтийн цэвэрлэгээнд ажилтан, албан хаагчдыг хамруулах, холбогдох зардлыг гаргаж цэвэрлэгээний багаж, хэрэгслээр хангах

3.4. Иргэн, аж ахуй нэгж, байгууллага нь сум, багаас зохион байгуулж буй хог хаягдлын талаарх сургалтад хамрагдах

3.5. Журмын 6.2-т заасан төрлөөр хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах

3.6. Аж ахуй нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо нь гадна талбайдаа журамд заасан төрлөөр хог хаягдал хадгалах шаардлага хангасан сав, бункертэй байх

3.6.1. Хогийн сав нь Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагаас гадна шавьж, мэрэгч, шувуу, амьтан орох боломжгүй хаалт, тагтай байна

3.6.2. Ангиллын төрлийг заасан таних тэмдэг, өнгөтэй байна

3.6.3. Хог хаягдлыг ангилж хийх, хадгалахад хялбар хийц загвартай, үзэмжтэй байна

3.6.4. Хогийн савыг тогтмол цэвэрлэж, сард нэгээс доошгүй удаа ариутгана

3.7. Барилга байгууламжийг өргөтгөх, шинээр барихдаа түүний зориулалт, хүн амын нягтрал, хог хаягдлын үүсэх хэмжээ, ангиллын төрлөөс хамаарч хог хаягдал хадгалах байр, талбайн байршлыг барилга, байгууламжийн зураг, төсөлд тусгасан байх

3.8. 0.75 метр кубээс дээш эзэлхүүнтэй, овор хэмжээ их энгийн болон барилгын хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуульд зааснаар нэмэлт үйлчилгээний хөлс төлж мэргэжлийн байгууллагаар тээвэрлүүлэх

3.9. Аж ахуй нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо, айл өрхүүд “Хог ачиж, тээвэрлүүлэх гэрээ”-г мэргэжлийн байгууллагатай байгуулж, ангиллын төрөл бүрээр хогоо ачуулах ба гэрээнд хог ачих өдөр, цаг, давтамжийг тодорхой заах, гэрээнд заасан нөхцөлөөр хогоо ачаагүй тохиолдолд Захирагчийн ажлын алба, тухайн багийн Засаг даргад мэдээлэх, санал хүсэлт гаргах

3.10. Бүх нийтийн цэвэрлэгээний өдрүүдэд хариуцуулсан нийтийн эзэмшлийн газар, зам талбайн хог хаягдлыг цэвэрлэж, холбогдох байгууллагад хүлээлгэж өгөх

### **ДӨРӨВ. НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГАЗАР, ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙГ ЦЭВЭРЛЭХ**

4.1. Нийтийн эзэмшлийн газар, гудамж, зам талбайн цэвэрлэгээг зам, талбайн онцлог, улирлын байдлаас шалтгаалан гараар болон тусгай зориулалтын машин техникээр гүйцэтгэнэ.

4.2. Аймгийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн газар, гудамж, зам талбайн цэвэрлэгээг гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна.

4.2.1. Гудамж, зам талбайн хог хаягдлыг механикаар цэвэрлэгч жижиг оврын тусгай зориулалтын авто машинтай байх

4.2.2. Ажилчдын ажлын хувцас солих өрөө, бие засах газар, халуун усанд орох нөхцөлийг бүрдүүлсэн түрээсийн болон өөрийн ажлын байртай байх

4.2.3. Зам талбайн цэвэрлэгээнд ажиллах шүүрт болон давс, бодис цацах тусгай зориулалтын авто машинтай байх ба автомашин нь стандартын шаардлага хангаж, тээврийн хэрэгслийн үзлэг, оношлогоонд хамрагдсан, байгаль орчин, агаарын чанарт сөрөг нөлөөгүй байх

4.2.4. Зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээнд ажиллах автомашин нь 5-аас дээш жилийн насжилттай бол агаарын бохирдлоос сэргийлэх зорилгоор автомашины түлш, яндангийн системд тусгай зориулалтын шүүлтүүр, тоног төхөөрөмж суурилуулсан байх

4.2.5. Цас мөс хайлуулах зориулалт бүхий бодис нөөцлөх шаардлага хангасан агуулахтай байх

4.2.6. Санхүүгийн чадавхитай байх, нийгмийн даатгал, татварын хугацаа хэтэрсэн өр, төлбөргүй байх

4.2.7. Цэвэрлэгээнд ашиглагдах автомашин, техник нь газар зүйн мэдээллийн (GPS) систем бүхий тоног төхөөрөмжтэй байх

4.3. Нийтийн эзэмшлийн газар, гудамж, зам талбайд дараах зам, талбайг хамруулна.

4.3.1. Олон улс, улс, орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж, тусгаарлах зурвас, гүүр, гүүрэн гарц, явган болон дугуйн зам, ногоон байгууламж, хайс, хашлага

4.3.2. Цэцэрлэгт хүрээлэн, талбай, хөшөө баримал, түүхийн дурсгалт газар

4.3.3. Орон сууц, гэр хорооллын доторх гол болон туслах зам, замын байгууламж, авто зогсоол, явган болон дугуйн зам, ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн

4.3.4. Голын эрэг, гольдол, амралт зугаалгын бүсийн ой мод, амралтын талбай, авто болон явган зам

4.4. Нийтийн эзэмшлийн газар, зам талбайн цэвэрлэгээний үйл ажиллагаанд тавигдах шаардлага.

4.4.1. Аймаг, сумын төвийн гол гудамж, зам, талбай, туслах зам талбайн цэвэрлэгээг өдөр бүр, хотоос алслагдсан болон хорооллын доторх зам талбайн цэвэрлэгээг долоо хоногт хоёроос доошгүй удаагийн давтамжтай цэвэрлэх

4.4.2. Зам талбайн нэг үйлчлэгчийн нэг удаагийн цэвэрлэх талбай 10000 метр квт-аас ихгүй байх

4.4.3. Авто зам, автобусны буудал, авто зогсоолын цэвэрлэгээг зуны улиралд өглөө 05:00-07:00 цаг, өвлийн улиралд 06:00-08:00 цагийн хооронд бүрэн хийж авто машин, явган зорчигч саадгүй зорчих нөхцөлийг хангах

4.4.4. Гэнэтийн болон байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсон үед ажлын цаг харгалзахгүйгээр ээлжээр цэвэрлэгээг хийх

4.4.5. Нийтийн эзэмшлийн газар, зам, талбайд байрлуулсан хогийн савны хог хаягдлыг хогийн сав дүүрч, халихаас өмнө давтамж харгалзалгүйгээр суллаж цэвэрлэх

4.4.6. Цас мөс хайлуулах зориулалтаар цацсан давс, тусгай зориулалтын бодис бүхий цас, мөсийг ногоон байгууламжид хийхгүй байх, хариуцсан зам талбайн цас, мөсийг цас орсон өдрөөс хойш 48 цагийн дотор бүрэн цэвэрлэх

4.4.7. Авто болон явган хүний замын хайс, хашлага, нийтийн эзэмшлийн газар, зам талбайн хогийн сав, сандал, бусад архитектурын байгууламжийг 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 10 дугаар сарын 1-ний өдрийн хооронд сард 1 удаа, бусад хугацаанд улиралд 1 удаа тус тус цэвэрлэх

4.4.8. Хатуу хучилттай автозам, явган болон дугуйн замыг дулааны улиралд гар болон механикаар чийгшүүлэн цэвэрлэнэ

4.5. Нийтийн эзэмшлийн газар, зам талбайн цэвэрлэгээг гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллага дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.5.1. Нийтийн эзэмшлийн зам, талбайн үйлчлэгч, жолооч, ачигчдыг өвөл, зуны ажлын хувцас, хэрэгсэл, багаж, материалаар хангах

4.5.2. Зам талбайн цэвэрлэгээний хуваарь, дараалал, аргачлалыг батлуулж ажиллах

4.5.3. Өвлийн улиралд авто зам болон зам талбайг цас орсон даруйд цэвэрлэх, халтиргаа, гулгаа арилгах зориулалтын бодис, давсыг цацаж, замын хөдөлгөөн хэвийн үргэлжлэх нөхцөлийг бүрдүүлэх

4.5.4. Цас, зуд, үер усны аюулын үед ажиллах шуурхай ажиллагааны төлөвлөгөө, нөөц авто машин, багаж, тоног төхөөрөмж, материалын тоо хэмжээ, нөөцийн судалгааг гарган байгууллагын даргаар батлуулж, аймгийн онцгой комисст улирал бүр хүргүүлэх

4.5.5. Цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг зориулалтын саванд хийж, хог хаягдал тээвэрлэх автомашинд ачуулах

4.5.6. Журмын 3.2-т заасны дагуу төлбөртэйгээр цэвэрлэгээ, үйлчилгээ үзүүлж, зардлыг гаргуулах

## **ТАВ. БҮХ НИЙТИЙН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ**

5.1. Бүх нийтийн их цэвэрлэгээнд дараах нийтийн эзэмшлийн газар, гудамж, талбай, ногоон бүсийг хамруулна.

5.1.1. Олон улс, улс, орон нутгийн чанартай авто зам дагуух 50 хүртэл метрийн өргөн зурвас

5.1.2. Төмөр замын хамгаалалтын бүсээс гадагш 50 хүртэл метрийн өргөн зурвас

5.1.3. Голын гольдрол, эрэг, түүний хамгаалалтын бүс

5.1.4. Амралт зугаалга, зуслан, ойн амралтын бүс

5.1.5. Орон сууцын хороолол, гэр хороолол дотор авто, явган болон дугуйн зам, ногоон байгууламж, бичил цэцэрлэг, гудамж, тоглоомын талбай, жалга, суваг, үер усны далан шуудуу

5.1.6. Цэвэрлэгээнд тогтмол хамрагддаггүй авто болон явган хүний зам, замын байгууламж, гудамж, талбай, цэцэрлэгт хүрээлэн, амралт зугаалгын бүс

5.2. Нийтийн их цэвэрлэгээнд тавигдах шаардлага.

5.2.1. Цэвэрлэсэн хог, хаягдлыг ил задгай орхих, шатаахгүй байх

5.2.2. Цэвэрлэгээнээс гарсан хог, хаягдлыг тусгайлан бэлтгэсэн уутанд хийж, уутны амыг боон хог хаягдал ачихаар тодорхойлсон байршилд хүргэх

5.2.3. Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдыг багш, эцэг эхийн хараа, хяналтан доор бүх нийтийн цэвэрлэгээнд оролцуулах

5.3. Бүх нийтийн цэвэрлэгээг улирлын онцлогийг харгалзан дараах төрлөөр гүйцэтгэнэ.

5.3.1. Хур хог цэвэрлэх, ачиж тээвэрлэх

5.3.2. Цас мөс цэвэрлэх, халтиргаа, гулгаа арилгах

5.3.3. Шарилж, лууль зэрэг хог ургамал цэвэрлэх

5.3.4. Нийтийн эзэмшлийн газар, гудамж талбайн хайс хашлага, архитектурын жижиг байгууламжийг угааж, цэвэрлэх, будаж өнгийг сэргээх

5.3.5. Авто зам дагуух хог хаягдлын түүвэр цэвэрлэгээ

5.3.6. Орон сууц, нийтийн зориулалттай байрны орц, шатны хонгилын цонх, хаалгыг угааж цэвэрлэх

5.3.4. Гэр хорооллын гудамж, жалга, далан сувагт үүссэн хог хаягдлыг цэвэрлэж, ачиж тээвэрлэх

5.3.5. Амралтын ногоон бүс, ой мод, голын эрэг, гольдролд үүссэн хог хаягдлыг цэвэрлэж, ачиж тээвэрлэх

## **ЗУРГАА. ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАХ**

6.1. Энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь дараах байдлаар ангилна.

6.1.1. Орон сууцны айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь дараах төрлөөр ангилна.

6.1.1.1. Дахин боловсруулах боломжтой хог хаягдал

6.1.1.2. Дахин боловсруулах боломжгүй хог хаягдал

6.1.1.3. Хүнсний органик хог хаягдал

6.1.2. Гэр хорооллын айл өрх, аж ахуй нэгж, байгууллага энгийн хог хаягдлыг дараах төрлөөр ангилна.

6.1.2.1. Дахин боловсруулах боломжтой хог хаягдал

6.1.2.2. Дахин боловсруулах боломжгүй хог хаягдал

6.1.2.3. Үнс буюу шаарга

6.1.2.4. Хүнсний органик хог хаягдал

6.2. Хог хаягдлын төрлийг дараах өнгөөр илэрхийлнэ.

6.2.1. Хуванцар, гялгал уут-Ногоон

6.2.2. Хөнгөн цагаан лааз, металл хаягдал-Улбар шар

6.2.3. Цаас-Цэнхэр

6.2.4. Шил-Цагаан

6.2.5. Хүнсний органик хаягдал-Бор

6.2.6. Бусад хог хаягдал-Хар

6.2.7. Аюултай хог хаягдал-Шар

6.3. Журмын 6.1-т заасан энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах төрлийг хог хаягдал дахин боловсруулах үйлдвэртэй уялдуулан аж ахуй нэгж, байгууллага, иргэд өөрсдийн санаачилгаар нэмэгдүүлж болно.

6.4. Нийтийн эзэмшлийн газар, гудамж талбайд байршуулах хогийн савыг хүн ихээр төвлөрдөг, энгийн хог хаягдал их хэмжээгээр үүсдэг дараах байршлуудад хог хаягдлын гарцын хэмжээнд нийцүүлэн байршуулна.

6.4.1. Төрөлжсөн зах, худалдааны төв

6.4.2. Үзвэр, үйлчилгээний газар

6.4.3. Төмөр зам, автобус, таксины зогсоол, буудал

6.4.4. Цэцэрлэгт хүрээлэн

6.4.5. Тохжилт бүхий амралтын талбай

6.4.6. Соёл амралтын хүрээлэн

## **ДОЛОО.ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ**

7.1. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ үзүүлэх байгууллага дараах шалгуурыг хангана.

7.1.1. Орон сууцны хороолол, аж ахуй нэгжийн хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх үйлчилгээ эрхлэх тохиолдолд хог ачиж тээвэрлэх өөрийн эзэмшлийн тусгай зориулалтын автомашинтай байх

7.1.2. Гэр хорооллын хог тээвэрлэх, үнс тээвэрлэх үйлчилгээ үзүүлэх тохиолдолд хог ачиж тээвэрлэх зориулалттай задгай тэвштэй, өөрөө буулгагч төхөөрөмжтэй өөрийн эзэмшлийн автомашинтай байх

7.1.3. Машин техникийн засварын тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл бүхий өөрийн эсвэл түрээсийн дулаан граж, авто баазтай байх

7.1.4. Хог хаягдлын менежмент, ачаа тээврийн чиглэлээр ажилласан туршлагатай инженер, техникийн 2-оос доошгүй ажилтантай байх

7.1.5. Санхүүгийн чадавхтай байх

7.1.6. Татварын хугацаа хэтэрсэн өргүй байх

7.1.7. Хог ачиж тээвэрлэх үйл ажиллагаанд оролцох машин техник нь газар зүйн мэдээллийн (GPS) систем бүхий тоног төхөөрөмжтэй байх

7.1.8. Хог тээврийн автомашин нь стандарт шаардлага хангаж, тээврийн хэрэгслийн үзлэг, оношлогоонд хамрагдсан, байгаль орчин, агаарын чанарт сөрөг нөлөөгүй байх

7.1.9. Байгаль орчин, агаарын чанарт сөрөг нөлөөлөл үзүүлэх, насжилтын зөвшөөрөгдөх түвшнээс дээш гарсан тээврийн хэрэгсэлд агаарын бохирдлоос сэргийлэх зорилгоор автомашины түлш, яндангийн системд тусгай зориулалтын шүүлтүүр, тоног төхөөрөмж суурилуулсан байх

7.1.10. Хог тээвэрлэх тусгай зориулалтын машин бүрт урд болон хойд талыг харах хар хайрцагны камер, мэдрэгч суурилуулсан байх

7.2. Аймгийн хэмжээнд хог хаягдал цуглуулж, тээвэрлэх үйлчилгээний гэрээг аймгийн Захирагчийн ажлын алба, сумдын Засаг дарга, хог хаягдлын үйлчилгээний байгууллага хамтран байгуулна

7.3. Гэрээнд хог хаягдал цуглуулж, тээвэрлэх үйлчилгээ эрхлэх байгууллагын сар бүрийн гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тусгана

7.4. Сумдын Засаг даргын Тамгын газар гэрээний шалгуур үзүүлэлтийн дагуу хог хаягдлын үйлчилгээний байгууллагад хяналт тавьж, сар бүрийн ажлын гүйцэтгэлд үнэлгээ өгнө

7.5. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ эрхлэх аж ахуй нэгж, байгууллага дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ

7.5.1. Энгийн хог хаягдал цуглуулалт тээвэрлэлтийн хуваарь, статистик тоо, мэдээ, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого, түүний зарцуулалт, маршрут, хүний нөөц, машин техник, тоног төхөөрөмжийн мэдээлэл, хог хаягдлын талаар хууль, эрх зүйн мэдээлэл, иргэдэд чиглэсэн хог хаягдлын сурталчилгааны мэдээлэл бүхий байгууллагын цахим хуудсыг ажиллуулах

7.5.2. Энгийн хог хаягдал цуглуулж тээвэрлэх үйлчилгээнд гарч буй жолооч, ачигчдыг хог хаягдлын талаарх хууль тогтоомж, харилцааны соёл, хог ачиж, цуглуулах тээвэрлэх арга зүй, хөдөлмөр, аюулгүй ажиллагааны сургалтад жилд 1-ээс доошгүй удаа хамруулах

7.5.3. Энгийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд ажиллаж буй жолооч, ачигчийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан өвөл, зуны ажлын хувцасаар жилд нэг удаа хангах

7.5.4. Өвчтэй, хэт ядарсан болон архи согтууруулах ундаа, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэсэн жолооч ачигчийг ажилд гаргахгүй байх

7.5.5. Цуглуулж, тээвэрлэсэн энгийн хог хаягдлын төрөл, эс үүсвэр, тоо хэмжээний талаарх мэдээг батлагдсан маягтын дагуу гаргаж, тогтоосон хугацаанд сумын Засаг даргад хүргүүлэх

7.5.6. Энгийн хог хаягдал цуглуулж, тээвэрлэх үйлчилгээний орлогын 2-оос доошгүй хувийг иргэдийн хог хаягдлын боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны үйл ажиллагаанд зарцуулах

7.5.7. Байгалийн давагдашгүй хүчин зүйл, байгалийн гамшгийн үед хог хаягдал цуглуулах, тээвэрлэх төлөвлөгөөг аймгийн Онцгой байдлын газартай зөвшилцөн боловсруулж, сумын Засаг даргаар батлуулан мөрдлөг болгон ажиллах

7.5.8. Хог ачих өдөр, хогоо гаргах цагийн хуваарийг мөрдүүлэх, хэвшүүлэх үйл ажиллагаанд багийн Засаг даргатай хамтран ажиллах

7.5.9. Энгийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ үзүүлэх тээврийн хэрэгслийг даатгал, үзлэг оношлогоонд бүрэн хамруулах, авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын хувийн хэрэг хөтлөх

7.5.10. Хог хаягдлын тухай хуулийн 14 дүгээр зүйл, олон улсын болон үндэсний стандартыг тус тус дагаж, мөрдөнө

7.5.11. Бүрэн бус тээврийн хэрэгсэл үйлчилгээнд гаргахгүй байх, автомашины бүрэн байдлыг шалгаж, ажилд гарах зөвшөөрөл олгох

7.5.12. Техникийн саатал, бусад тодорхой шалтгааны улмаас хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх хуваарийг зөрчихгүйн тулд нөөц машин техник, ачигчтай байх

7.5.13. Энгийн хог хаягдлыг автомашины даац, тэвшний өндөрт тохируулан ачиж, битүүмжлэн тээвэрлэх ба тээвэрлэлтийн явцад хог хаягдал хийсэх, тарах, асгарахаас сэргийлэх арга хэмжээг авах

7.5.14. Энгийн хог хаягдал ачиж тээвэрлэсний дараа тээврийн хэрэгсэл болон тэвхийг тогтмол цэвэрлэж, сард 2-оос доошгүй удаа ариутгал, халдваргүйжүүлэлт хийх

7.5.15. Шахаж нягтруулах төхөөрөмж бүхий автомашиныг байгалийн давагдажгүй хүчин зүйлээс бусад тохиолдолд энгийн хог хаягдал тээвэрлэхээс бусад тохиолдолд ашиглахгүй байх

7.5.16. Дараах нөхцөлд хог тээврийн авто машиныг үйлчилгээнд гаргахгүй байх арга хэмжээг авч ажиллах

7.5.16.1. Тоног төхөөрөмж, нягтруулах механизм, өргүүрийн эд ангиас шингэн алдагдсан

7.5.16.2. Хог тээвэрлэх чингэлэг цоорсон, битүүмжлэл алдагдсан, өнцгийн бэхэлгээ, гогцоо, тулгуур эвдэрсэн, өргөх механизмын тогтоох чадвар, нягтруулагчийн явагч ажиллахгүй болсон

7.5.17. Хог хаягдлын төвлөрсөн цэгт тээвэрлэсэн энгийн хог хаягдлыг бүртгүүлж, жинлүүлэн зөвхөн төвлөрсөн цэгийн чиглүүлэгчийн заасан хог хаягдал хүлээн авах талбайд буулгах, аюулгүй байдлыг хангаж ажиллах

7.5.18. Хог хаягдал тээвэрлэх зориулалттай тээврийн хэрэгслийн тэвш, ачаан дээр хүн тээвэрлэхгүй байх

7.5.19. Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад хог ачих хуваарийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэх

7.5.20. Хог ачиж цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаанд мэдээллийн технологи, шинэ инновацийг нэвтрүүлж ажиллах

7.7. Хог хаягдлыг ачиж цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаанд дараах шаардлагыг баримтлана.

7.7.1. Орон сууцны хорооллын хог хаягдлыг долоо хоногт 4-өөс доошгүй удаа, гэр хорооллын хог хаягдыг долоо хоногт 2-оос доошгүй удаа, аж ахуй нэгж, байгууллагын хог хаягдлыг долоо хоногт 1-өөс доошгүй удаа цуглуулж, ачиж тээвэрлэх

7.7.2. Айл өрх, аж ахуй нэгж, байгууллагын хог хаягдлыг хугацаа бага зарцуулах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, жолооч ачигчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах



байдлаар ачиж, цуглуулах арга, хэлбэр, технологийг сонгох бөгөөд хог хаягдал ачиж буулгах, цуглуулах, ангилал төрлөөс шалтгаалан зориулалтын уут, хогийн сав ашиглах

7.7.3. Хог хаягдлыг ачих, цуглуулахад дуут дохио, чанга яригч, хөгжмийг 09.00 цагаас 18.00 цагийн хооронд эмнэлэг, цэцэрлэг, сургууль болон орон сууцны хороолол дунд ашиглахгүй байх

7.7.4. Аж ахуй нэгж, байгууллага, орон сууцны байр, нийтийн эзэмшлийн газар, гудамж, талбайн хогийн сав, бункерт дүүргэлтийн дохиолол бүхий мэдрэгч суурилуулж болох ба дүүргэлтийг 90 хувиас хэтрүүлэхгүйгээр тогтмол хуваарийн дагуу тухай бүр ачиж тээвэрлэх

7.7.5. Энгийн хог хаягдлыг ачиж, цуглуулах үед галын аюулгүй байдлыг хангах, хог хаягдлын цэгээс 10 метрийн дотор гал гаргахгүй байх

7.7.6. Энгийн хог хаягдлыг ачсаны дараа хогийн сав, бункер болон орчныг цэвэрлэх

7.7.7. Хогийн сав, бункер эзэмшигч, өмчлөгч, ашиглагч дулааны улиралд сард нэг удаа, хүйтний улиралд хоёр сард нэг удаа угааж, ариутгал халдваргүйжүүлэлт хийх

7.7.8. Нийтийн эзэмшлийн газар, гудамж, талбайн хогийн сав болон аж ахуй нэгжийн хогийн цэгээс хог хаягдлыг шөнийн цагаас цуглуулж, тээвэрлэж болох бөгөөд хөдөлмөрийн болон замын хөдөлгөөний аюулгүй ажиллагааг ханган, гэрэлтүүлэгтэй орчинд гүйцэтгэх, иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулах дуут дохио, чанга дуу авиа гаргахгүй байх

7.7.9. Энгийн хог хаягдал ачиж, тээвэрлэх хуваарь, чиглэл өөрчлөгдсөн тохиолдолд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 48 цагийн өмнө мэдэгдэх

7.7.10. Энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйлчилгээг тухайн сумын нэр, байгууллагын лого, бүртгэлийн дугаар бүхий харагдахуйц таних тэмдэгтэй авто машинаар гүйцэтгэх

7.7.11. Аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7.1-д заасан аргачлалын дагуу эзэлхүүнд суурилж тооцож авна

7.7.12. Хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага тээвэрлэж байгаа хог хаягдлын төрөл, ангилалаас хамаарч хог дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагатай хог хаягдал нийлүүлэх гэрээ байгуулж ажиллана.

## **НАЙМ. ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ, СЭРГЭЭН АШИГЛАХ**

8.1. Энгийн хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагааг Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.2-д заасан зөвшөөрөл авсан, 8 дугаар зүйлийн 8.1.9.б-д заасны дагуу бүртгүүлж, журмын 1.6-д заасан гэрээ байгуулсан хуулийн этгээд гүйцэтгэнэ.

8.2. Энгийн хог хаягдал дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагаа эрхлэгч Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасан журмын дагуу дахин боловсруулсан болон сэргээн ашигласан хог хаягдлын мэдээ, тайланг тогтоосон хугацаанд аймгийн Захирагчийн ажлын албанд ирүүлнэ.

8.3. Энгийн хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагаа эрхлэгч Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаар байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэнэ.

8.4. Энгийн хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагаа эрхлэгчид тавигдах нэмэлт шаардлага.

8.4.1. Хог хаягдал дахин боловсруулах, сэргээн ашиглах технологи хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байх

8.4.2. Дахин боловсруулсан бүтээгдэхүүн байгаль орчинд сөрөг нөлөөгүй, хүн, мал, амьтан, ургамалд аюулгүй, Монгол Улсын болон олон улсын стандартад нийцсэн, хүний хэрэгцээ шаардлага хангасан байх

8.4.3. Техник, тоног төхөөрөмжийн аюулгүй үйл ажиллагаа, засвар үйлчилгээ хийх заавар, дүрэм, аргачлал боловсруулах

8.4.4. Хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах үйлдвэрт гамшгийн эрсдлийн нөлөөллийн үнэлгээ хийлгэж, аймгийн Онцгой байдлын газраар батлуулж, менежментийн төлөвлөгөөг боловсруулж үе шаттай хэрэгжүүлэх

8.4.5. Дахин боловсруулах, сэргээн ашиглах хог хаягдал хүлээн авах талбай хатуу хучилттай, дээвэртэй, хог хаягдал салхиар тархах, хийсэхээс сэргийлсэн хашаатай ба хог хаягдлын бүтэц, найрлагыг тогтоох, хэмжих, ачиж буулгах, шахаж нягтруулах техник, тоног төхөөрөмжтэй байх

8.4.6. Эрүүл ахуйн шаардлага хангасан, лабораторийн шинжилгээгээр хүлээн зөвшөөрөгдсөн хог хаягдлаар дахин боловсруулсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх

8.4.7. Хог хаягдал дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагаа эрхлэгч 30 хоногийн хугацаанд туршилтын үйлдвэрлэлийг явуулан, үйл ажиллагааны горим, технологийн үзүүлэлт, агаарт ялгарах бодисын хэмжээг тогтоож, стандарт шаардлага хангасан тохиолдолд үйл ажиллагааг эхлэх

8.5. Төвлөрсөн хогийн цэгт хүргэх боломжгүй суурин газарт өндөр даралт болон битүүмжлэл бүхий хог хаягдал шатаах зориулалтын, байгаль орчин сөрөг нөлөөгүй, байгаль орчны холбогдох байгууллага хүлээн зөвшөөрсөн жижиг оврын хог хаягдал шатаах байгууламж ашиглан дулаан, халуун ус үйлдвэрлэж хог хаягдлыг сэргээн ашиглаж болно

8.6. Шатаах зуухны ачаалал, хүчин чадлаас илүү гарсан болон зуухны бүтцэд өөрчлөлт гарах, зуухны үйл ажиллагааны үзүүлэлт зөвшөөрөгдсөн хязгаараас давсан тохиолдолд шатаах зуухны үйл ажиллагааг зогсоож хэвийн нөхцөлд орсон тохиолдолд дахин ажиллуулна

8.7. Хог хаягдал дахин боловсруулах, сэргээн ашиглах төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгжид Газрын тухай хууль, бусад хууль тогтоомжид заасны дагуу газар олголт болон дэд бүтцээр дэмжлэг үзүүлнэ.

8.8. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуй нэгжүүд бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа хог хаягдлыг дахин боловсруулсан бүтээгдэхүүнийг нэн тэргүүнд сонгоно.

## **ЕС. ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ УСТГАХ, БУЛШЛАХ**

9.1. Энгийн хог хаягдлын устгах, булшлах үйл ажиллагаанд өдөр тутмын хөндлөнгийн хяналтыг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болох ба захиалагч хяналтын төрийн бус байгууллагыг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж ажиллуулна.

9.2. Хөндлөнгийн хяналтын үйл ажиллагааг устгах, булшлах үйл ажиллагааны 2 хувиар санхүүжүүлнэ.

9.3. Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийг дараах байдлаар төлөвлөнө.

9.3.1. Хог хаягдлын төвлөрсөн цэгийг төлөвлөхдөө хог хаягдлын суурь судалгааг үндэслэн хог хаягдлын бүтэц, нягт, үүсэх хэмжээг харгалзан булшлах технологийг сонгох

9.3.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө, олон улсын зээл, тусламжаар байгуулах хог хаягдал булшлах, устгах байгууламжийн газар тухайн сумын эзэмшилд байх ба нэг, хоёрдугаар зэрэглэлийн төвлөрсөн цэгийг хаасны дараа тогтоосон хугацаанд байгаль орчны хяналт, мониторинг хийх

9.3.3. Аймгийн хэмжээнд хог хүлээн авч устгах, булшлах хог хаягдлын төвлөрсөн цэгийг Хог хаягдлын тухай хуулийн 17.1, 17.4, 17.5, 17.6 дахь заалтуудад заасан шаардлагуудыг хангасан зэрэглэлд хамруулсан байдлаар төлөвлөж, хамгаалалтын бүсийг тогтоох

9.3.4. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн байршлыг сонгох, төлөвлөхөд тухайн орон нутгийн иргэдийн оролцоог хангаж ажиллах

9.3.5. Нэг, хоёрдугаар зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэгийг төлөвлөх тохиолдолд хөрсний болон гүний усны шинжилгээ хийж төлөвлөсөн талбайн хамгийн өндөр цэг, хог хаягдал булшлах талбай, хог хаягдлын төвлөрсөн цэгийн хамгийн нам цэгт өрөмдлөг хийж дээж авна.

9.4. Хог хаягдлын төвлөрсөн цэгийг төлөвлөх, зураг төслийг хийхэд доорх хүчин зүйлсийг харгалзана.

9.4.1. Тухайн сонгосон нутаг дэвсгэрт 15-аас дээш жил хог хаягдал хүлээн авах нөөцтэй эсэх

9.4.2. Хөрсөөр хучих шороо, хөрс олборлох боломжтой

9.4.3. Хууль тогтоомжоор хориглосон байршил болон хог хаягдлын төвлөрсөн цэгийн хил, хязгаарын зааг шаардлагад нийцсэн

9.4.4. Салхины зонхилох чиглэл

9.4.5. Дэд бүтэц, авто замын сүлжээ, харилцаа холбоо

9.4.6. Бусад

9.5. Хог хаягдлын ландфилыг талбайг төлөвлөхдөө доорх шаардлагыг харгалзана.

9.5.1. Шимт хөрсийг нөөцлөн хог хаягдлын төвлөрсөн цэгийн ногоон байгууламж болон нөхөн сэргээлтэд ашиглах

9.5.2. Мод, бут, сөөгийг шилджүүлэн суулгах

9.5.3. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн үүрийг ухаж бэлтгэх, гарсан шороог үерийн хамгаалалтын далан эсвэл хучилтад нөөцлөх

9.5.4. Суурийг бэлтгэхдээ 2 градусуас доошгүй налуутай шүүрлийн ус цуглуулах боломжтой бэлтгэх

9.5.5. Хог хаягдлын бүтэц, жилийн дундаж хур тунадасны хэмжээ, хогийн цэгт устгаж, булшлах хогийн хэмжээ, хими, физикийн шинж чанараас шалтгаалан суурийн хучилтын технологийг сонгох

9.5.6. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар аймгийн нутаг дэвсгэрт хог хаягдлыг булшлах, хог хаягдлын төвлөрсөн цэгийг барьж байгуулах тохиолдолд аймгийн Засаг даргаас зөвшөөрөл авч, гэрээ байгуулан ажиллана.

9.6. Энгийн хог хаягдлыг устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэгч байгууллага дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

9.6.1. Ажилтан, албан хаагчдыг өвөл болон зуны улирлын хөдөлмөр хамгааллын багаж хэрэгсэл, ажлын хувцас гутлаар хангах

9.6.2. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн үүр болон хог хаягдлын талбайд ил гал гаргах, тамхи татах болон шатах, тослох материал агуулахгүй байх

9.6.3. Хог хаягдлын төвлөрсөн цэгт мал, амьтан оруулах, бэлчээх, тэжээхгүй байх

9.6.4. Хог хаягдлын төвлөрсөн цэгт ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдыг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, эрүүл мэндийн болон гэнэтийн ослын даатгалд хамруулах

9.6.5. Хог хаягдлын төвлөрсөн цэгт хүлээн авч устгаж булшилсан хог хаягдлын дэлгэрэнгүй бүртгэл бүхий мэдээллийн сантай байх бөгөөд энэхүү мэдээллийн санг зөвшөөрөгдсөн байгууллагуудад тухай бүр ашиглуулах

9.6.6. Хог хаягдлын төвлөрсөн цэгт хог хаягдлыг хүлээн авах ландфилын талбай, аюул, осол, байгалийн гамшгийн үед хог хаягдал хүлээн авах нөөц талбай, хог хаягдал булшлах хөрс бэлтгэж нөөцлөх талбайг тус тус төлөвлөх ба энэхүү төлөвлөлтийг жил бүр гаргаж, байгууллагын даргаар батлуулах

9.6.7. Дахин боловсруулах хог хаягдал түүгч иргэдийг хог хаягдлын төвлөрсөн цэгийн талбайд нэвтрүүлэхгүй, хог түүх үйл ажиллагааг эрхлүүлэхгүй байх

9.6.8. Төвлөрсөн хогийн цэгийн харуул, хамгаалалтыг мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх

9.6.9. Хог хаягдлын төвлөрсөн цэгт хог хаягдлыг тээвэрлэж ирсэн иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас тухайн хог хаягдлыг дарж булах, устгах зардлыг Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4-т заасан энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифаар тооцож авах

9.7. Энгийн хог хаягдлыг устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах шаардлага:

9.7.1. Хог хаягдлыг зөвхөн төлөвлөж, батлагдсан талбайд хүлээж авна. Байгалийн гамшигт үзэгдэл, давагдашгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд аймгийн Захирагчийн ажлын албатай зөвшилцөн нөөц талбайд хүлээн авах

9.7.2. Хог хаягдлыг хүлээн авах ажлын талбайд хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах үйл ажиллагааг эрхлэхгүй байх

9.7.3. Нэг болон хоёрдугаар зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэгт өдөр бүр, гуравдугаар зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэгт хог хаягдлыг долоо хоногт 2-оос доошгүй удаа шороон хөрсөөр хучиж, нягтруулах ба хучих зузаан 15 см-ээс багагүй байна.

9.7.4. Биологийн болон хими, физикийн аргаар хог хаягдлыг устгахдаа ашиглах бодис, технологийн талаарх мэдээллийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэж, дүгнэлт гаргуулан аймгийн Захирагчийн ажлын албанаас зөвшөөрөл авсны дараа гүйцэтгэх

9.7.5. Хэт хуурайшилттай, халуун, салхи шуургатай үед хог хаягдал хийсэх, агаарт тоосонцор үүсэхээс сэргийлэн хог хаягдал хүлээн авч буй талбайг усаар норгож чийглэх, хог хаягдал шатаж, гал гарсан тохиолдолд шуурхай унтраах зорилгоор усан сан болон ус шүрших төхөөрөмж бүхий усны машинтай байх бөгөөд гал унтраах ажиллагаанд оролцох ажилтнууд гал унтраах сургалтад хамрагдах

9.7.6. Хог хаягдал булшлах, устгах байгууламж уруу орох замыг хөрсөөр хучиж, нягтруулан хог тээврийн авто машин саадгүй зорчих нөхцлийг бүрдүүлэх

9.7.7. Хог хаягдлын төвлөрсөн цэг дээр ажиллаж буй хүнд даацын техник хэрэгсэл болон авто машинуудын үйл ажиллагаанд хяналт, мониторинг хийх боломжтой газар зүйн (GPS) систем, хог хүлээн авч байгаа талбайд камер суурилуулах

9.7.8. Хог хаягдал тээвэрлэн ирж байгаа авто машиныг ачаатай үед хог хаягдлын төвлөрсөн цэгт орох пүүн дээр жигнэж бүртгэн хэмжилт хийж, ачиж тээвэрлэсэн хог хаягдлын эс үүсвэр, хог хаягдлын төрлийг тодорхойлж, шаардлагатай тохиолдолд хяналтын ажилтан ачиж, тээвэрлэсэн хог хаягдлыг шалгаж биологийн, химийн болон аюултай, шатах, дэлбэрэх эрсдэлтэй хог хаягдал илэрвэл хог хаягдлыг төвлөрсөн цэгт нэвтрүүлэхгүй байх

9.7.9. Хог хаягдлыг буулгасны дараа хог хаягдлын төвлөрсөн цэгээс авто машин гарахад ачаагүй үеийн авто машины жинг хэмжиж, пүүлэх бөгөөд ачаатай үеийн жингийн зөрүүгээр хог хаягдлын төвлөрсөн цэгт зөөвөрлөгдөн ирсэн хог хаягдлын хэмжээг бүртгэж, баталгаажуулна.

9.7.10. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн бүртгэлийн байр дараах тоног төхөөрөмжтэй байна

9.7.10.1. Авто машины дугаар мэдрэгч бүхий хяналтын камер

9.7.10.2. Авто машины жинг хариулсан гадна мэдээллийн дэлгэц

9.7.10.3. Авто машинд ачсан хог хаягдлын бүтцийг хянах камер

9.7.10.4. Бүртгэлийн программ хангамж бүхий иж бүрэн компьютер, хэвлэх төхөөрөмж

9.7.10.5. Дотор болон гадна хяналтын камер

9.7.10.6. Бүртгэл, программ хангамжтай холбоотой дижитал авто пүү

9.7.10.7. Тээврийн хэрэгслийн дугуй ариутгах, цэвэрлэх төхөөрөмж

9.7.10.8. Гадна гэрэлтүүлэг

9.7.11. Хог хаягдлын төвлөрсөн цэгт шингэн хог хаягдал, хүний шарил, эд эрхтэн, тэсэрч дэлбэрэх, химийн аюултай хог хаягдал булшлахгүй байх

9.8. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн үйл ажиллагаанаас үүсэх агаар, хөрс, усанд ялгарах ялгаралд жилд нэг удаа хяналт, шинжилгээ хийх, ялгарал нь стандарт шаардлагаас өндөр болсон тохиолдолд шалтгаан нөхцөлийг тогтоон, засварлаж дахин шинжилгээ хийнэ

9.9. Хаалтын хучилт хийгдсэн болон нөхөн сэргээлт хийсэн талбайг эргүүлэн ухаж, хог хаягдлыг гаргаж, тараахыг хориглох ба зайлшгүй тохиолдолд аймгийн Захирагчийн ажлын албанаас зөвшөөрөл авч ухаж болох бөгөөд эргүүлэн нөхөн сэргээлтийг хийнэ

9.10. Төвлөрсөн хогийн цэг нь дараах хүнд даацын машин механизм, техник, тоног төхөөрөмжтэй байна

9.10.1. Хүнд даацын гинжит бульдозер

9.10.2. Экскаватор

9.10.3. Хучилтын хөрс, шороо тээвэрлэх тээврийн хэрэгсэл

9.10.4. Ус шүрших тоноглол бүхий усны машин

9.10.5. Гал унтраах иж бүрэн тоног, төхөөрөмж, хувцас, хэрэгсэл

9.11. Төвлөрсөн хогийн цэгт гамшгийн эрсдлийн нөлөөллийн үнэлгээ хийлгэж, аймгийн Онцгой байдлын газраар батлуулан, менежментийн төлөвлөгөөг батлуулна

9.12. Хог хаягдлын төвлөрсөн цэгт дарж булшлах үйл ажиллагааг Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.11-д заасны дагуу булшилсан хог хаягдлын хэмжээгээр тооцож санхүүжүүлнэ.

## **АРАВ.ХАРИУЦЛАГА**

10.1. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, аж ахуй нэгж, байгууллагад Зөрчлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

10.2. Журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

10.3. Хог хаягдлын үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэхтэй холбоотой маргааныг хоёр тал харилцан зөвшилцөж шийдвэрлэх ба зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

ТӨСӨЛ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны  
.....дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

### НИЙТИЙН ЭДЭЛБЭР ГАЗРЫН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ

№	Ажлын нэр	Хэмжих нэгж /м.кв/	Үнийн тариф /төгрөг/
1	Аймгийн нутаг дэвсгэрт мөрдөх нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх тариф	1	3,77

### ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ БУЛШЛАХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ

№	Ажлын нэр	Хэмжих нэгж /тн/	Үнийн тариф /төгрөг/
1	Аймгийн нутаг дэвсгэрт мөрдөх нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг булшлах тариф	1	3687

Тайлбар:Цэвэрлэх, булшлах ажилд ашиглах машин техникийн марк, тухайн үеийн зах зээлийн шатахууны үнэ ханшнаас хамаараад тариф хэлбэлзэж болно.

---o0o---